

ТАНЫ САНХҮҮГИЙН ГЭРЭЛ

Үйл ажиллагааны тайлан /2024 он/

- 1 Компанийн танилцуулга
- 2 Бизнесийн үйл ажиллагаа
- 3 Онцлох үйл явдал
- 4 Санхүүгийн тайлан
- 5 Компанийн засаглал

1 Компанийн танилцуулга

Эрхэм зорилго

Харилцагчдад энгийн эрсдэлгүй, хүртээмжтэй, хэрэгцээнд зохицож, шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн гэрэл-хөгжлийн түшиг байх болно.

Алсын хараа

Бичил санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээ, ёс зүй бүхий салбартаа тэргүүлэгч санхүүгийн байгууллага болно.

Үнэт зүйлс

- Сэтгэл ханамжтай ажилтан
- Харилцагч төвтэй шинэлэг үйлчилгээ
- Ёс зүйтэй хамтын ажиллагаа
- Тогтвортой өндөр өгөөж



Байгууллагын нэр	“Гэрэл Финанс ББСБ” ХХК
Регистрийн дугаар	5832551
Үйл ажиллагаа эхэлсэн огноо	2015.04.22
Үйл ажиллагааны чиглэл	<ul style="list-style-type: none"> • Зээл • Итгэлцлийн үйл ажиллагаа, • Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ • Финтек аппликейшн
Хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Тусгаар тогтнолын талбай гудамж, МН тауэр барилга, 1207 тоот

Салбарын тоо	3
Нийт хөрөнгийн хэмжээ	16,011,024,298.42 төгрөг
Өөрийн хөрөнгийн хэмжээ	10,771,346,258.98 төгрөг
Үйл ажиллагааны чиглэл	Зээл, Итгэлцлийн үйл ажиллагаа, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, Финтек
Финтек зээлийн аппликейшн	GEREL
Нийт идэвхтэй зээлийн тоо	30,662




2024.12.31-ний байдлаар

2 Бизнесийн үйл ажиллагаа

2024 онд нийт давхардсан тоогоор 58.5 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчдад олгосон. Үүнээс 46.4 тэрбум төгрөгийн зээлийг GEREL зээлийн аппликейшнээр дамжуулан олгосон байна. Нийт идэвхитэй зээлийн тоо 30,662-д хүрсэнээс 29,844 нь GEREL зээлийн аппликейшнээр дамжуулан зээл авсан харилцагчид байна. Зээлийн багц 14.6 тэрбумд хүрч өмнөх оны эцсээс 73%-иар өссөн.



2023 оны 12 сард GEREL зээлийн аппликейшний 2.0 хувилбарыг ашиглалтанд оруулсан. Мөн 2024.12.09-нд биржийн бус зах зээлд 2 тэрбум төгрөгийн бондыг амжилттай гаргаж хөрөнгө татан төвлөрүүлэн зээлийн олголтоо нэмэгдүүлсэн тул харилцагчдын тоо болон зээлийн багц өссөн.



3 Онцлох үйл явдал, 2024 он

GEREL зээлийн аппликейшн харилцагчдын хүрээгээ тэлж 21 аймгийн төвүүдэд зээл олгож эхэллээ.



Бид 2021-2023 онуудад Улаанбаатар хотын харилцагчдадаа GEREL зээлийн аппликейшнаар дамжуулан финтек зээлийн үйлчилгээг үзүүлж байсан бол 2024 оноос Монгол улсын 21 аймгын төвийн харилцагчдад GEREL зээлийн аппликейшнаар дамжуулан финтек зээлийн үйлчилгээг үзүүлж эхэллээ.

Биржийн бус зах зээл/ОТС/- д Gerel finance BOND 4 гаргаж 2 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлэв.



Гэрэл финанс ББСБ-ын 7 дахь удаагын / биржийн бус зах зээлийн 5 дахь/ хаалттай өрийн бичиг “Gerel finance BOND 5”-ийг амжилттай гаргаж, 2 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлэв. Мөн 2024 онд Итгэлцлийн үйлчилгээний бүтээгдэхүүнээ шинэчлэн Шаталсан хүүт итгэлцлийг харилцагчдад санал болгон 1.5 тэрбум төгрөгийн итгэлцэл татсан байна.

Баянзүрх дүүрэгт шинэ салбараа нээв.

Гэрэл финанс ББСБ-ын зээл олголтыг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын зүүн бүсийн иргэдэд хүрч үйлчлэхээр Баянзүрх дүүргийн 16-р хороо, Офицеруудын тойрогт шинэ салбараа 2024 оны 7 сард нээлээ.



Шинэ салбарт дараах зээлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Шинэ автомашины лизинг
- Автомашин барьцаалсан зээл
- Орон сууц барьцаалсан зээл
- Хашаа байшин барьцаалсан зээл
- Үнэт дугаар барьцаалсан зээл

Мэдээллийн аюулгүй байдлын магадлан аудит хийлгэж ISO 27001:2013 сертификатыг дахин баталгаажуулав.



Мэдээллийн аюулгүй байдлын Олон улсын стандартыг тасралтгүй ханган ажиллаж, 2024 онд магадлан аудит хийлгэн баталгаажууллаа. ISO 27001:2013 стандартад нийцсэнээр харилцагч таны мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна

БИЗКОН АУДИТ ХХК

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧЛЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

2025 он 02 сар 04 өдөр

Дугаар СТА-14/25

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ГЭРЭЛФИНАНС ББСБ” ХХК-ийн удирдлагад

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн “Гэрэлфинанс ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид, “Гэрэлфинанс ББСБ” ХХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-уудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ийн дүрэм” гэх)-ийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л. ОТГОНБАЯР

Санхүүгийн тайлан

Санхүү байдлын тайлан

"Гэрэл Финанс ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2024 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
(төгрөг)		
Санхүүгийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	668,056,362.87	408,171,425.23
Нийт зээл	8,115,564,382.23	14,489,956,372.28
Бусад санхүүгийн хөрөнгө	245,009,330.67	15,568,101.00
Санхүүгийн хөрөнгийн дүн	9,028,630,075.77	14,913,695,898.51
Санхүүгийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	479,168,770.80	930,797,369.64
Биет бус хөрөнгө	111,870,000.00	114,720,000.00
Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	51,811,030.27
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	591,038,770.80	1,097,328,399.91
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,619,668,846.57	16,011,024,298.42
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Санхүүгийн өр төлбөр		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	1,262,292,460.00	1,746,100,345.23
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	477,850,000.00	938,369,639.42
Бусад эх үүсвэр	2,000,000,000.00	2,026,712,329.00
Бусад санхүүгийн өр төлбөр	100,954,179.55	132,425,060.52
Санхүүгийн өр төлбөрийн дүн	3,841,096,639.55	4,843,607,374.17
Санхүүгийн бус өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өглөг	147,014,117.57	396,070,665.27
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	147,014,117.57	396,070,665.27
Нийт өр төлбөрийн дүн	3,988,110,757.12	5,239,678,039.44
Эзэмшигчдийн өмч		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	3,570,000,000.00	5,275,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг	10,600,000.00	10,600,000.00
Хуримтлагдсан ашиг	2,050,958,089.45	5,485,746,258.98
Эзэмшигчдийн өмчийн дүн	5,631,558,089.45	10,771,346,258.98
НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	9,619,668,846.57	16,011,024,298.42

Аудитор:

Б.Наранбат

Хүлээн зөвшөөрсөн:

Орлогын тайлан

"Гэрэл Финанс ББСБ" ХХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
(төгрөг)		
Хүүгийн орлого	2,629,435,779.22	5,755,051,656.06
Хүүгийн зардал	276,645,541.63	730,664,542.63
Цэвэр хүүгийн орлого	2,352,790,237.59	5,024,387,113.43
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	-	-
Хүүгийн бус орлого	62,813,370.75	128,268,000.00
Хүүгийн бус зардал	910,253,826.27	1,118,932,210.52
Бусад зардал	-	23,172,048.00
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/ алдагдал	1,505,349,782.07	4,010,550,854.91
Зээлийн эрсдэлийн зардал	214,421,005.89	199,598,907.09
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	1,290,928,776.18	3,810,951,947.82
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	1,290,928,776.18	3,810,951,947.82
Орлогын татварын зардал	129,093,057.63	376,163,778.29
Цэвэр ашиг/алдагдал	1,161,835,718.55	3,434,788,169.53

Аудитор:

Б.Наранбат

Хүлээн зөвшөөрсөн:

5 Компанийн засаглал

“Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, түүний үнэлгээ

“Гэрэл финанс ББСБ” ХХК нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг зорин ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тэргүүлэгч ТОП 10 ББСБ-уудын нэгээр шалгарч байсан.Цаашид Компани нь өөрийн үнэлгээг тогтмол сайжруулах, шаардлагатай баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэхэд анхаарч ажиллах болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



С.БАТМӨНХ
ТУЗ-ийн дарга
Хувьцаа
эзэмшигч



Б.СУГАРБОЛД
ТУЗ-ийн гишүүн
Гүйцэтгэх захирал



М.Байгалмаа
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны дарга
Гэрэл финанс ББСБ-ын
Хуулийн зөвлөх



Л.ДАВААСАМБУУ
ТУЗ-ийн гишүүн
Засаглал, нэр
дэвшүүлэх болон
цалин урамшууллын
хорооны дарга



Д.Бямбажав
ТУЗ-ийн гишүүн
Аудитын хорооны
дарга

ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа

ТУЗ нь ердийн 3, хараат бус 2 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.Тус онд төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 3 удаа ээлжит болон ээлжит бус хурал хийж, 5 асуудал шийдвэрлэн 8 тогтоол гаргасан байна. ТУЗ нь байнгын ажиллагаа бүхий 1- Эрсдэлийн удирдлагын хороо, 2- Аудитын хороо,3- Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Хувьцаа эзэмшилт	2023 оны ТУЗ-ийн хурлын ирц	Цалин (төгрөг)	ТУЗ-д ажилласан хугацаа
С.Батмөнх	100%	100%	500,000	4 жил
М.Байгалмаа	Байхгүй	100%	500,000	4 жил
Л.Даваасамбуу	Байхгүй	100%	500,000	4 жил
Д.Бямбажав	Байхгүй	100%	500,000	4 жил
Б.Сугарболд	Байхгүй	100%	500,000	4 жил

Компанийн засаглал

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Аудитын хороо	Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо	Эрсдэлийн удирдлагын хороо
Д.Бямбажав (Хорооны дарга)	Л.Даваасамбуу (Хорооны дарга)	М.Байгалмаа (Хорооны дарга)
М.Байгалмаа	М.Байгалмаа	Л.Даваасамбуу
Л.Даваасамбуу	Д.Бямбажав	Д.Бямбажав
Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 2 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Төлөөлөн удирдах зөвлөлд өгч ажиллалаа	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, ТУЗ-ийн хараат бус гишүүний хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг хийж ажиллав.	Эрсдэлийн удирдлагын хороо нь тайлант жилийн хугацаанд Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна

Гэрэл финанс ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүх эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 2024 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

Дотоод аудитын тогтолцоо

Додоод аудитын зорилго.

Дотоод аудит нь "Гэрэл финанс ББСБ"-ын бизнесийн үйл ажиллагаанд баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээгээр дамжуулан Компаний засаглал, санхүүгийн үр дүнтэй байдал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үр дүнтэй байдлыг хараат бус, бодит байдлаар үнэлнэ.

Дотоод аудитын тогтолцоо.

Дотоод аудитын газар нь хараат бус байх ба ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд харъяалагдаж, тайлагнана.

Дотоод аудит нь хараат бус, бодит байдлыг бий болгож ажиллана.

Хараат бус, бодит байдал алдагдсан эсвэл алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Аудитын хороонд мэдэгдэнэ.

Дотоод аудитын бүтэц, зохион байгуулалт.

Дотоод аудит нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд харъяалагдаж тайлагнана.

Дотоод аудит нь аудитын стандарт, ёс зүйн дүрэм, Дотоод аудитын дүрэм, журамд нийцүүлж ажиллана.

Дотоод аудитын чиг үүрэг.

Дотоод аудит нь эрсдэлд суурилсан аудитын орчныг тодорхойлж, Гүйцэтгэх захирал болон

ТУЗ-ийн санал дээр үндэслэн дотоод аудитын төлөвлөгөө гаргаж ажиллана.

Дотоод аудит нь байгууллагад нөлөөлж болзошгүй шинээр үүсч буй асуудлуудыг анхааралдаа авч ажиллана.

Дотоод аудит нь тасралтгүй сайжруулалт хийнэ.

Аудитын төлөвлөгөөнд тусгасан аудит тус бүрийн зорилт, хамрах хүрээ, шалгалтын үр дүн, аудитын дүгнэлт болон зөвлөмжийг холбогдох талуудад танилцуулна.

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын мэдээлэл

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний хүрээнд ажлаа гүйцэтгэж байна. Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын хэмжээг холбогдох хууль тогтоомж, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ЗНДЦУХ-ны хурлаар хэлэлцэн тодорхойлдог бөгөөд шагнал урамшууллын хэмжээг санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлттэй уялдуулан жил бүр гаргасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгууртай уялдуулан тогтоож Гүйцэтгэх захирлын гэрээнд тусган баталгаажуулдаг. ЗНДЦУХ-ны зүгээс санхүүгийн жил дуусгавар болсны дараа Гүйцэтгэх захирлын тухайн хугацааны үйл ажиллагаа нь Гүйцэтгэх захирлын гэрээнд туссан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдэд хүрч буй эсэх буюу Компанийн жилийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай нэг бүрчлэн харьцуулан тодорхойлж, шагнал урамшуулал олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх бодлогыг баримталж байна.

Компанийн засаглал

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Гэрэл финанс ББСБ” ХХК нь Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд үнэт цаас гаргагч мөн Итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татан төвлөрүүлдэг компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон харилцагчдынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажилладаг сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ. Манай байгууллага нь хууль тогтоомж, дотоод болон гадаад дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийн нийцэл, санхүүгийн үнэн зөв тайлагнал, үндсэн үйл ажиллагааны үр дүнтэй байдал болон үр ашгийг нэмэгдүүлж урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд Үйл ажиллагааны эрсдэлийн гадаад болон дотоод орчны хүчин зүйлсийг улирал тутам шинэчлэн үнэлж алба нэгжүүдэд эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, холбогдох журам заавраар хангахын сацуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд тайлагнаж ажилласнаар Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх, засаглалыг тасралтгүй сайжруулах үндсэн зорилгыг хэрэгжүүлсэн байна. Зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллах зарчмын хүрээнд холбогдох журмуудыг дотоод үйл ажиллагаа болон хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, мөн үйл ажиллагаанд шаардлагатай шинэ журмыг боловсруулж ажилласан.

Гэрэл финанс ББСБ-ын голлох эрсдэлүүд:

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үйл явдал, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх; - Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх; 	<ul style="list-style-type: none"> - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав.
Санхүүгийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах; - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох; - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох; - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах; 	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлсэн. - Тогтмол тайлагналт хийж байв. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаатай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллана.
Зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зээлийн багцын чанар буурах; - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх; - Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх; 	<ul style="list-style-type: none"> - Компанийн дотоод бодлого, журам, бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн баталлаа. - Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлалыг дахин шинэчлэв.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн үйлчилгээ зөвхөн иргэдэд үзүүлдэг. -Тус үйл ажиллагааг явуулахад байгаль орчинд нөлөөлөх эрсдэл бусад салбартай харьцуулбал харьцангуй бага тул байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэж үзэж байна. 	<ul style="list-style-type: none"> -Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. -Байгаль орчинд ээлтэй эко автомашины зээл тогтол гаргаж байна.